

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХҮЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ**

2019 оны 03 дугаар сарын 05-ны өдөр

Дугаар A-57

Улаанбаатар хот

**МОНГОЛ УЛСЫН 2021 ОНД НЭМЭЛТЭЭР ИМПОРТЛОХ СТРАТЕГИЙН**

**ЗАРИМ ХҮНСНИЙ НЭР ТӨРӨЛ, ТОО ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ**

Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 329 дүгээр тогтоолоор баталсан "Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журам", Хүнсний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийн 2021 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн хуралдааны 7 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- 1."Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем"-д үндэслэсэн гадаад худалдааны барааны ангиллын жагсаалтад нийцүүлэн 2021 онд нэмэлтээр импортлох стратегийн зарим хүнсний нэр төрөл, тоо хэмжээг хавсралтад заасны дагуу тогтоосугай.
- 2.Стратегийн хүнсийг импортлох зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг "Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журам"-ын дагуу зохион байгуулахыг ажлын хэсэг (Л.Чой-Иш)-т, зөвшөөрлийг хууль, тогтоомж, энэхүү тушаалд нийцүүлэн олгож ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Т.Жамбалцэрэн)-д тус тус даалгасугай.
- 3.Тушаалыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэн, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх арга хэмжээ авахыг Хуулийн хэлтэс (Э.Цолмонжаргал)-т үүрэг болгосугай.

САЙД 3.МЭНДСАЙХАН